



**САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН
ХОРШООДЫН
2022 ОНЫ ГУРАВДУГААР
УЛИРЛЫН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН
ТАНИЛЦУУЛГА**

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГАЗАР

УЛААНБААТАР ХОТ

АГУУЛГА

НЭГ.САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	2
1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл.....	2
1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл.....	3
1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл.....	3
1.4 Бодлого, зохицуулалтын орчин.....	5
ХОЁР.НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД	6
2.1 Статистик үзүүлэлтүүд.....	6
2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд.....	8
2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....	9
2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....	10
ГУРАВ.НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	10
3.1 Хөрөнгийн бүтцийн талаар.....	10
3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар.....	12
3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар.....	12
3.4 Зээлийн чанарын талаар.....	12
ДӨРӨВ.НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	15
4.1 Эх үүсвэрийн бүтцийн талаар.....	15
4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар.....	16
4.3 Бусдаас авсан зээл, өр төлбөрийн талаар.....	16
4.4 Бусад богино хугацаат өр төлбөрийн талаар.....	17
4.5 Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн талаар.....	17
4.6 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар.....	18
ТАВ.ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГАА	18
5.1 ХЗХ-дын орлогын талаар.....	18
5.2 ХЗХ-дын зардлын талаар.....	19
5.3 ХЗХ-дын ашигт ажиллагааны талаар.....	19
ЗУРГАА.ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	20
6.1 ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар.....	20
ДОЛОО.ДҮГНЭЛТ	21

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2022 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2022.11.04


Улаанбаатар хот

НЭГ. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл

2022 оны 3 дугаар улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон 202 хадгаламж, зээлийн хоршоо (цаашид “ХЗХ” гэх) үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23 ХЗХ буюу 10.2 хувиар буурсан үзүүлэлт юм. Тайлант улиралд нийт ХЗХ-дын 45.5 хувь буюу 92 ХЗХ орон нутагт, 54.5 хувь буюу 110 ХЗХ Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулсан байна.

График 1: ХЗХ-дын тоо /хот, орон нутгаар/




Тайлант улиралд Хорооны хуралдаанаар 5 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 2 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх асуудлыг шийдвэрлэсэн байна. Мөн 1 ХЗХ-нд санхүүгийн түрээсийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл нэмж олгосон бөгөөд 15 ХЗХ-ны 137 сонгуульт гишүүн, 13 гүйцэтгэх захирал, 11 нягтлан бодогч, 1 ХЗХ-ны ажлын байрны хаягийн

өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэсэн байна.

Хүснэгт 1: ХЗХ-дын тусгай зөвшөөрлийн мэдээлэл

Он	2018	2019	2020	2021	2022.III
ХЗХ-дын тоо	279	261	249	209	202
Шинээр олгосон	18	17	14	-	7
Хүчингүй болгосон	29	35	26	40	14
Түдгэлзүүлсэн	19	10	23	12	9
Сэргээсэн	7	1	6	1	3
ТЗ-ийн хугацаа сунгасан	100	52	49	85	34

Зураг 1: ХЗХ-дын эрхэлж буй үйл ажиллагаа




1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл

2022 оны 3 дугаар улирлын байдлаар 202 ХЗХ-ны 703 ажилтан, 72,770 гишүүн /72,555 иргэн, 215 хуулийн этгээд/-тэйгээр Монгол Улсын 21 аймаг, 8 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байна.

Улаанбаатар хотын 8 дүүрэгт 110 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17 ХЗХ буюу 13.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд хамгийн их төвлөрөлтэй байна.

Зураг 2: Улаанбаатар хотын ХЗХ-дын тархалт



Орон нутагт Сэлэнгэ аймгаас бусад 20 аймагт 92 ХЗХ үйл ажиллагаа явуулж байна. Баян-Өлгий, Увс, Говь-Алтай, Ховд, Дорнод аймгуудад төвлөрөл их байгаа бол Булган, Говьсүмбэр, Өвөрхангай, Сүхбаатар, Хэнтий аймагт тус бүр 1 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 3: ХЗХ-дын тархалт



Тайлант улирлын байдлаар нийт 202 ХЗХ 63 салбартайгаар үйл ажиллагаа эрхэлж байна.

1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл


2022 оны 3 дугаар улирлын байдлаар ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,001 гишүүн буюу 4.0 хувиар буурч 72,770-д хүрсэн үзүүлэлттэй байна. Нийт гишүүдийн 0.3 хувь буюу 215 хуулийн этгээд, 54.0 хувь буюу 39,314 эмэгтэй гишүүн байна.

Зураг 4: ХЗХ-ны гишүүдийн мэдээлэл



Нийт гишүүдийн 56.0 хувь буюу 40,739 гишүүн Улаанбаатар хотод бүртгэлтэй бол 44.0 хувь буюу 32,031 гишүүн орон нутагт бүртгэлтэй байна.

График 3: ХЗХ-дын тоо болон гишүүдийн өөрчлөлт /хот, орон нутгаар/



Сүүлийн 5 жилийн хугацаанд ХЗХ-дын тоо буурсан ч 2018-2021 оны 3 дугаар улирлын байдлаар гишүүдийн тоо тогтмол өсөж байсан бол тайлант хугацаанд 4.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг ХЗХ-дын гишүүдийн 13.4 хувь буюу 5,463 гишүүн “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд байгуулагдсан 51 ХЗХ-ны гишүүд байна.

Мөн тайлант улиралд “Ногоон алт малын эрүүл мэнд төсөл”-ийн санхүүжилттэй 29 ХЗХ 11,351 гишүүнтэй үйл ажиллагаа явуулсан байна.


Нийт 202 ХЗХ-ны 38.1 хувь буюу 77 ХЗХ 20-100 гишүүнтэй, 47.5 хувь буюу 96 ХЗХ 101-500 гишүүнтэй, 9.4 хувь буюу 19 ХЗХ 501-1,000 гишүүнтэй, 5.0 хувь буюу 10 ХЗХ 1,001-ээс дээш гишүүнтэй байна.

Хүснэгт 2: ХЗХ-ны гишүүнчлэл, интервалаар

Гишүүд /интервалаар/	ХЗХ-ны тоо	Гишүүд	Эзлэх хувь
20-100 гишүүнтэй	77	4,328	5.9%
101-500 гишүүнтэй	96	20,475	28.1%
501-1,000 гишүүнтэй	19	13,354	18.4%
1,001-ээс дээш гишүүнтэй	10	34,613	47.6%
Нийт	202	72,770	100.0%

Гишүүдийн төвлөрлийг хүснэгтээр харуулбал 1,001-ээс дээш гишүүнтэй 10 ХЗХ-ны гишүүд нийт гишүүдийн 47.6 хувийг эзэлж байна.

График 4: ХЗХ-ны гишүүдийн төвлөрөл



1.4 Бодлого, зохицуулалтын орчин

Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

- Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны "Бичил санхүүгийн байгууллагыг чадавхжуулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл"-ийг хариуцсан мэргэжилтний Монгол Улсад ажилласан томилолтын хүрээнд 2022.09.22-ны өдөр уулзаж төслийн хэрэгжилт, явцын талаар мэдээлэл өгсөн.
- Хадгаламж, зээлийн хоршооны зах зээлд 2022-2024 онд хэрэгжүүлэх Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны ТА-6883 MON: "Хүртээмжтэй, ногоон сэргэлтийн төлөө Зүүн Азийн жендерийн тэгш байдлыг эрчимжүүлэх төсөл"-ийн дэд хэсэг "Ногоон санхүүгийн хүртээмж, жендерийн тэгш байдлыг дэмжих төсөл"-ийн дотоодын зөвлөх ажиллаж эхэлсэн.

Хууль, эрх зүйн орчин

- Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан "Заавар, дансны жагсаалт, аргачлал болон маягт батлах тухай" 2012 оны 232/216 дугаар тушаалыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлж, шинэчлэн боловсруулахтай холбоотойгоор Сангийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2022.09.20-ны өдрийн А/156 тоот тушаалаар байгуулсан ажлын хэсэгт Хорооны төлөөлөл ажиллаж байна. Энэ хүрээнд "Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны нэгдсэн жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга бэлтгэх аргачлал"-ын төслийг боловсруулж МХЗХҮХ-оос санал авсан.
- Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын хамтарсан 2018 оны 274/А-256/541/59 дүгээр тушаалаар батлагдсан

"Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан банкнаас бусад санхүүгийн салбарын мэргэжлийн оролцогчийн ёс зүйн журмыг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд мөрдөгдөх "Ёс зүйн дүрмийн үлгэрчилсэн загвар"-ын төслийг боловсруулж МХЗХҮХ-оос санал авсан.

Хурал, семинар, уулзалт

- Монголбанкны ерөнхийлөгчийн 2022.04.29-ний өдрийн А-127 дугаар тушаалаар байгуулагдсан "Банк, эрх бүхий байгууллагын мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэгт заасан "Зээл, хадгаламжийн хүүгийн аргачлал, мэдээллийн ил тод байдлын тухай журам боловсруулах" ажлын хэсэгт Хорооны төлөөлөл ажиллаж байгаа бөгөөд журамд өөрчлөлт оруулах саналыг 2022.09.07-ны өдөр ажлын хэсгийн нарийн бичгийн даргад цахимаар хүргүүлсэн.
- Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Жижиг дунд үйлдвэрлэлийн газрын хамтарсан Бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн боловсрол олгох сургалтын төлөвлөгөөний дагуу 2022.09.26-ны өдөр Сүхбаатар дүүрэг, 2022.09.29-ний өдөр Баянзүрх дүүргийн ЖДҮ-ийн эрхлэгчдийг хамруулан зохион байгуулсан сургалтад "Банк болон банкнаас бусад санхүүгийн байгууллага" сэдвээр мэдээлэл өгсөн.
- Зээлийн батлан даалтын сантай хамтран ХЗХ-дыг зээлийн батлан даалтын сангийн үйлчилгээнд хамруулах, бүтээгдэхүүний судалгаа хийх ажлын хүрээнд 2022.08.12-ны өдөр Төв аймагт үйл ажиллагаа эрхэлж байгаа хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаатай газар дээр нь танилцсан.

ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тусгай зөвшөөрөлтэй 202 ХЗХ-оос 2022 оны 3 дугаар улирлын тайлангийн нэгтгэлд 10 ХЗХ өмнөх улирлын тайлангаар хамрагдсан.

2.1 Статистик үзүүлэлтүүд

Хүснэгт 3: ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Статистик мэдээлэл	ХЗХ-ны нийт гишүүд		Үүнээс:			
			Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
ХЗХ-дын тоо	202	100.0%	110	55.0%	92	45.5%
Нийт гишүүдийн тоо	72,770	100.0%	40,739	56.0%	32,031	44.0%
Эрэгтэй	33,241	45.7%	16,963	51.0%	16,278	49.0%
Эмэгтэй	39,314	54.0%	23,630	60.1%	15,684	39.9%
Гишүүн хуулийн этгээд	215	0.3%	146	67.9%	69	32.1%
Гишүүдийн насжилт	72,555	100.0%	40,593	55.9%	31,962	44.1%
18-35 насны	20,376	28.1%	11,899	58.4%	8,477	41.6%
36-45 насны	21,481	29.6%	12,565	58.5%	8,916	41.5%
46-55 насны	17,629	24.3%	9,110	51.7%	8,519	48.3%
55-аас дээш	13,069	18.0%	7,019	53.7%	6,050	46.3%
Гишүүдийн боловсрол	72,555	100.0%	40,593	55.9%	31,962	44.1%
Дээд	30,366	41.9%	20,713	68.2%	9,653	31.8%
Тусгай дунд	12,618	17.4%	7,624	60.4%	4,994	39.6%
Бүрэн дунд	20,486	28.2%	11,156	54.5%	9,330	45.5%
Дунд	6,412	8.8%	941	14.7%	5,471	85.3%
Бага	2,673	3.7%	159	5.9%	2,514	94.1%
Нийт ажилтнуудын тоо	703	100.0%	408	58.0%	295	42.0%
Үүнээс: эмэгтэй	488	69.4%	291	59.6%	197	40.4%
Санхүүгийн програмтай	100	49.5%	43	21.3%	57	28.2%
Монголбанкны СМА-нд 20 сая төгрөгөөс дээш бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлсэн ХЗХ-дын тоо	15	100.0%	11	73.3%	4	26.7%
Гүйлгээний тоо	1,327	100.0%	1,298	97.8%	29	2.2%
Гүйлгээний дүн /мян.төг/	197,591,487.42	100.0%	184,880,997.87	93.6%	12,710,489.56	6.4%
Монголбанкны СМА-нд сэжигтэй гүйлгээг мэдээлсэн ХЗХ-дын тоо	0	0	0	0	0	0
Сэжигтэй гүйлгээний тоо	0	0	0	0	0	0
Сэжигтэй гүйлгээний дүн /мян.төг/	0	0	0	0	0	0


2022 оны 3 дугаар улирлын байдлаар нийт ХЗХ-дын 7.4 хувь буюу 15 ХЗХ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7.1-д заасны дагуу Монголбанкны СМА-нд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний нийт 197,591,487.42 мянган төгрөгийн 1,327 гүйлгээг мэдээлсэн байна. Дээрх гүйлгээний дүнгийн 93.6 хувь буюу 184,880,997.87 мянган төгрөгийн 1,298 гүйлгээг Улаанбаатар хотын 11 ХЗХ, 6.4 хувь буюу 12,710,489.56 мянган төгрөг бүхий 29 гүйлгээг орон нутгийн 4 ХЗХ мэдээлсэн

байна. Тайлант улирлын байдлаар сэжигтэй гүйлгээ гараагүй байна.

ХЗХ-дын нийт гишүүдийн 57.7 хувийг 18-45 насныхан эзэлж байна. Гишүүдийн насжилтыг хот, орон нутгаар харьцуулахад Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн насжилт орон нутгийн ХЗХ-дын гишүүдээс харьцангуй залуу байна.


Нийт гишүүдийн 41.9 хувь нь дээд боловсрол эзэмшсэн байна. Гишүүдийн боловсролын түвшинг хот, орон нутгаар харьцуулахад Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн боловсролын түвшин орон нутгийн ХЗХ-дын гишүүдээс өндөр буюу дээд боловсролтой нийт гишүүдийн 68.2 хувь нь Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд байна.

График 5: ХЗХ-ны гишүүдийн насжилт, УБ, орон нутгаар



- Орон нутаг дахь ХЗХ-дын гишүүдийн насжилт
- Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн насжилт

График 6: ХЗХ-дын гишүүдийн боловсролын түвшин, УБ, орон нутгаар



- Орон нутаг дахь ХЗХ-дын гишүүдийн боловсролын түвшин
- Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн боловсролын түвшин

Хүснэгт 4: ХЗХ-дын зээлдэгчдийн статистик үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Статистик мэдээлэл	ХЗХ-дын нийт зээлдэгч		Үүнээс:			
			Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
ХЗХ-дын тоо	202	100.0%	110	54.5%	92	45.5%
Нийт зээлийн үлдэгдэл	216,086,474.94	100.0%	167,904,442.86	77.7%	48,182,032.09	22.3%
Нийт зээлдэгчийн тоо	38,212	100.0%	22,198	58.1%	16,014	41.9%
Иргэн	38,116	99.7%	22,112	99.6%	16,004	99.9%
Эмэгтэй	18,153	47.5%	9,685	43.6%	8,468	52.9%
Хуулийн этгээд	96	0.3%	86	0.4%	10	0.1%
Зээлдэгчдийн насжилт	38,116	100.0%	22,112	58.0%	16,004	42.0%
18-35 насны	9,150	24.0%	5,158	23.3%	3,992	24.9%
36-45 насны	11,017	28.9%	6,155	27.9%	4,862	30.4%
46-55 насны	9,347	24.5%	5,159	23.3%	4,188	26.2%
55-аас дээш	8,602	22.6%	5,640	25.5%	2,962	18.5%
Зээлдэгчдийн боловсрол	38,116	100.0%	22,112	58.0%	16,004	42.0%
Дээд	12,548	32.9%	7,588	34.3%	4,960	31.0%
Тусгай дунд	7,954	20.9%	4,779	21.6%	3,175	19.8%
Бүрэн дунд	7,436	19.5%	2,848	12.9%	4,588	28.7%
Дунд	4,985	13.1%	2,574	11.6%	2,411	15.1%
Бага	5,193	13.6%	4,323	19.6%	870	5.4%

Тайлант улиралд ХЗХ-д 38,212 зээлдэгчийн 216,086,474.94 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Нийт зээлдэгчийн 58.1 хувь буюу 22,198 зээлдэгч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт зээлийн 77.7 хувь буюу 167,904,442.86 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 41.9 хувь буюу 16,014 зээлдэгч орон нутгийн ХЗХ-дын гишүүд ба нийт зээлийн 22.3 хувь буюу

48,182,032.09 мянган төгрөгийг бүрдүүлж байна.

Нийт зээлдэгчийн 99.7 хувь буюу 38,116 нь хувь хүн (47.5 хувь буюу 18,153 нь эмэгтэй), 0.3 хувь буюу 96 нь хуулийн этгээд байна.

Нэг зээлдэгчид ногдох дундаж зээл 5,654.94 мянган төгрөг байгаа бөгөөд тус үзүүлэлт Улаанбаатар хотод 7,563.94 мянган төгрөг, орон нутагт 3,008.4 мянган төгрөг байна.

Хүснэгт 5: ХЗХ-дын хадгаламж эзэмшигчдийн статистик үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Статистик мэдээлэл	ХЗХ-дын нийт хадгаламж эзэмшигч		Үүнээс:			
	Тоо	Хувь	Улаанбаатар хот		Орон нутаг	
			Тоо	Хувь	Тоо	Хувь
ХЗХ-дын тоо	202	100.0%	110	54.5%	92	45.5%
Нийт хадгаламжийн үлдэгдэл	189,762,780.52	100.0%	151,829,341.57	80.0%	37,933,438.95	20.0%
Нийт хадгаламж эзэмшигчийн тоо	37,666	100.0%	19,236	51.1%	18,430	48.9%
Эмэгтэй	20,751	55.1%	10,378	54.0%	10,373	56.3%
Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл	2,678,272.12	1.4%	2,181,284.40	1.4%	496,987.73	1.3%
Хугацаагүй хадгаламж эзэмшигчийн тоо	3,951	10.5%	2,981	15.5%	970	5.3%
Иргэн	3,929	10.4%	2,961	15.4%	968	5.3%
Хуулийн этгээд	22	0.1%	20	0.1%	2	0.0%
Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл	187,084,508.40	98.6%	149,648,057.17	98.6%	37,436,451.23	98.7%
Хугацаатай хадгаламж эзэмшигчийн тоо	33,715	89.5%	16,255	84.5%	17,460	94.7%
Иргэн	33,671	89.4%	16,245	84.5%	17,426	94.6%
Хуулийн этгээд	44	0.1%	10	0.1%	34	0.2%
Хадгаламж эзэмшигчдийн насжилт	37,600	100.0%	19,206	100.0%	18,394	100.0%
18-35 насны	13,294	35.3%	7,974	41.5%	5,320	28.9%
36-45 насны	10,192	27.1%	5,025	26.2%	5,167	28.1%
46-55 насны	8,114	21.6%	3,670	19.1%	4,444	24.2%
55-аас дээш	6,000	16.0%	2,537	13.2%	3,463	18.8%
Хадгаламж эзэмшигчдийн боловсрол	37,600	100.0%	19,206	100.0%	18,394	100.0%
Дээд	17,695	47.1%	12,044	62.7%	5,651	30.7%
Тусгай дунд	5,118	13.6%	2,308	12.0%	2,810	15.3%
Бүрэн дунд	8,686	23.1%	3,537	18.4%	5,149	28.0%
Дунд	3,976	10.6%	907	4.7%	3,069	16.7%
Бага	2,125	5.6%	410	2.2%	1,715	9.3%

2022 оны 3 дугаар улирлын байдлаар ХЗХ-д 37,766 хадгаламж эзэмшигчийн 189,762,780.52 мянган төгрөгийн хадгаламжийг татан төвлөрүүлсэн байна. Нийт хадгаламж эзэмшигчийн 51.1 хувь буюу 19,236 хадгаламж эзэмшигч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 80.0 хувь буюу 151,829,341.57 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 48.9 хувь буюу 18,430 хадгаламж эзэмшигч нь орон нутгийн ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 20.0 хувь буюу 37,933,438.95 мянган төгрөгийг бүрдүүлж байна.

2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд

2022 оны 3 дугаар улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 266,660,249.42 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.8 хувь буюу 22,711,432.78 мянган төгрөгөөр буурч

Нийт хадгаламж эзэмшигчийн 10.5 хувийг хугацаагүй, 89.5 хувийг хугацаатай хадгаламжтай гишүүд эзэлж байна.

Нийт хадгаламж эзэмшигчийн 99.8 хувь буюу 37,600 нь хувь хүн (55.1 хувь буюу 20,751 нь эмэгтэй), 0.2 хувь буюу 66 нь хуулийн этгээд байна.

Нэг хадгаламж эзэмшигчид ногдох дундаж хадгаламж 5,038.04 мянган төгрөг байгаа бөгөөд тус үзүүлэлт Улаанбаатар хотод 7,828.98 мянган төгрөг, орон нутагт 2,058.24 мянган төгрөг байна.

банкны зах зээлийн 0.6 хувьтай тэнцэж байна.

Тайлант улиралд нийт зээлийн үлдэгдэл 3.9 хувь буюу 8,021,087.73 мянган төгрөгөөр өсөж, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 6.9 хувь буюу 14,044,425.29 мянган

төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт орлого 5.3 хувь буюу 2,232,489.61 мянган төгрөг, нийт зарлага 5.3 хувь буюу 1,836,751.48 мянган төгрөгөөр

тус тус нэмэгдэж, нийт цэвэр орлого 5.5 хувь буюу 395,738.13 мянган төгрөгөөр өсөж 7,542,706.06 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 6: ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2021 оны III улирал	2022 оны III улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
Нийт хөрөнгө	289,371,682.20	266,660,249.42	-22,711,432.78	-7.8%
Банкны салбарт эзлэх хувь	0.7%	0.6%		
Нийт зээл	208,065,387.21	216,086,474.94	8,021,087.73	3.9%
Банкны салбарт эзлэх хувь	1.0%	0.9%		
Нийт чанаргүй зээл	8,002,953.94	7,848,282.36	-154,671.58	-1.9%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	3.8%	3.6%	-0.2%	-5.6%
Банкны салбарт эзлэх хувь	0.4%	0.3%	-0.1%	-24.2%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	203,807,205.81	189,762,780.52	-14,044,425.29	-6.9%
Банкны салбарт эзлэх хувь	1.1%	1.2%		
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	25,675,069.91	26,069,990.69	394,920.78	1.5%
Нийт хоршоологчдын өмч Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	34,839,689.56	29,858,120.06	-4,981,569.50	-14.3%
Нийт орлого	8,847,586.72	6,185,587.71	-2,661,999.00	-30.1%
Нийт зарлага	41,782,547.56	44,015,037.17	2,232,489.61	5.3%
Цэвэр орлого, алдагдал	34,635,579.64	36,472,331.11	1,836,751.48	5.3%
	7,146,967.92	7,542,706.06	395,738.13	5.5%

2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 110 ХЗХ-ны нийт хөрөнгө 209,488,075.19 мянган төгрөг нь зах зээлийн 78.6 хувь, нийт зээл 167,904,442.86 мянган төгрөг нь зах зээлийн 77.7 хувь, нийт хадгаламж 151,829,341.57 мянган төгрөг нь зах зээлийн 80.0 хувийг тус тус бүрдүүлж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.3 хувь буюу 525,131.76 мянган төгрөгөөр буурч 6,665,767.86 мянган төгрөгт хүрсэн нь нийт зээлийн 4.0 хувийг эзэлж байна. Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл өмнөх оны мөн үеэс 29.8 хувь

буюу 2,608,321.82 мянган төгрөгөөр буурсан байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 1.3 хувь буюу 430,647.21 мянган төгрөгөөр, нийт зарлага 0.6 хувь буюу 178,492.49 мянган төгрөгөөр буурч, нийт цэвэр орлого 4.7 хувь буюу 252,154.73 мянган төгрөгөөр буурч 5,092,982.83 төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Улаанбаатар хотын ХЗХ-дын 70.0 хувь буюу 77 ХЗХ “Монголбанкны зээлийн мэдээллийн санд мэдээлэл өгөх, авах гэрээ”-г байгуулсан байна.

Хүснэгт 7: Улаанбаатар хотын ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2021 оны III улирал	2022 оны III улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
Нийт хөрөнгө	241,714,463.78	209,488,075.19	-32,226,388.58	-13.3%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	83.5%	78.6%	-4.9%	-5.9%
Нийт зээл	168,629,971.75	167,904,442.86	-725,528.89	-0.4%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	81.0%	77.7%	-3.3%	-4.1%
Нийт чанаргүй зээл	7,190,899.62	6,665,767.86	-525,131.76	-7.3%
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	89.9%	84.9%	-5.0%	-5.5%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	4.3%	4.0%	-0.3%	-7.7%

Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	171,882,716.24	151,829,341.57	-20,053,374.67	-11.7%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	84.3%	80.0%	-4.3%	-5.1%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	19,572,893.14	19,539,485.82	-33,407.33	-0.2%
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	76.2%	75.0%	-1.2%	-1.6%
Нийт хоршоологчдын өмч	28,107,841.82	21,010,021.38	-7,097,820.45	-25.3%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	80.7%	70.4%	-10.3%	-12.8%
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	8,757,809.54	6,149,487.71	-2,608,321.82	-29.8%
Нийт орлого	33,093,338.98	32,662,691.77	-430,647.21	-1.3%
Нийт зарлага	27,748,201.42	27,569,708.93	-178,492.49	-0.6%
Цэвэр орлого, алдагдал	5,345,137.56	5,092,982.83	-252,154.73	-4.7%

2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 92 ХЗХ-ны нийт хөрөнгө 57,172,174.23 мянган төгрөг нь зах зээлийн 21.4 хувь, нийт зээлийн үлдэгдэл 48,182,032.09 мянган төгрөг нь зах зээлийн 22.3 хувь, нийт хадгаламж 37,933,438.95 мянган төгрөг нь зах зээлийн 20.0 хувийг тус тус эзэлж байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 30.6 хувь буюу 2,663,136.82 мянган төгрөг, нийт зарлага 29.3 хувь буюу 2,015,243.96 мянган

төгрөгөөр тус тус өсөж, цэвэр орлого 36.0 хувь буюу 647,892.86 мянган төгрөгөөр нэмэгдэж 2,449,723.23 мянган төгрөгт хүрсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу орон нутгийн ХЗХ-дын 33.7 хувь буюу 31 ХЗХ “Монголбанкны зээлийн мэдээллийн санд мэдээлэл өгөх, авах гэрээ”-г байгуулсан байна.

Хүснэгт 8: Орон нутгийн ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2021 оны III улирал	2022 оны III улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
Нийт хөрөнгө	47,657,218.42	57,172,174.23	9,514,955.81	20.0%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	16.5%	21.4%	4.9%	29.9%
Нийт зээл	39,435,415.47	48,182,032.09	8,746,616.62	22.2%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	19.0%	22.3%	3.3%	17.4%
Нийт чанаргүй зээл	812,054.32	1,182,514.49	370,460.18	45.6%
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	10.1%	15.1%	5.0%	49.2%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	2.1%	0.7%	-1.4%	-66.5%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	31,924,489.57	37,933,438.95	6,008,949.38	18.8%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	0.5%	20.0%	19.5%	3898.0%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	6,102,176.77	6,530,504.87	428,328.10	7.0%
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	23.8%	25.0%	1.2%	5.3%
Нийт хоршоологчдын өмч	6,731,847.74	8,848,098.69	2,116,250.95	31.4%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	19.3%	29.6%	10.3%	53.5%
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	89,777.18	36,100.00	-53,677.18	-59.8%
Нийт орлого	8,689,208.58	11,352,345.40	2,663,136.82	30.6%
Нийт зарлага	6,887,378.21	8,902,622.18	2,015,243.96	29.3%
Цэвэр орлого, алдагдал	1,801,830.37	2,449,723.23	647,892.86	36.0%

ГУРАВ. НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


3.1 Хөрөнгийн бүтцийн талаар

Хүснэгт 9: ХЗХ-дын хөрөнгийн бүтэц /мянган төгрөгөөр/

ХӨРӨНГӨ	2021 оны III улирал		2022 оны III улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлтийн хөрөнгө	277,950,090.21	96.1%	262,521,933.24	98.4%	-15,428,156.97	-5.6%
Мөнгөн хөрөнгө	63,776,794.65	22.0%	30,491,169.46	11.4%	-33,285,625.19	-52.2%
Бэлэн мөнгө	4,543,296.60	1.6%	6,376,060.31	2.4%	1,832,763.71	40.3%
Банкинд байршуулсан харилцах	21,129,197.45	7.3%	12,984,244.25	4.9%	-8,144,953.19	-38.5%
Банкинд байршуулсан хадгаламж	38,104,300.61	13.2%	11,130,864.89	4.2%	-26,973,435.71	-70.8%
Богино хугацаат хөрөнгө оруулалт	150,000.00	0.1%	220,000.00	0.1%	70,000.00	46.7%
Арилжааны үнэт цаас	150,000.00	0.1%	220,000.00	0.1%	70,000.00	46.7%

Зээл /цэврээр/	202,508,927.27	70.0%	210,404,840.91	78.9%	7,895,913.65	3.9%
Нийт зээл	208,065,387.21	71.9%	216,086,474.94	81.0%	8,021,087.73	3.9%
Хэвийн зээл	194,506,245.06	67.2%	203,009,266.12	76.1%	8,503,021.06	4.4%
Хугацаа хэтэрсэн зээл	5,556,188.21	1.9%	5,228,926.46	2.0%	-327,261.75	-5.9%
Чанаргүй зээл	8,002,953.94	2.8%	7,848,282.36	2.9%	-154,671.58	-1.9%
(Зээлийн эрсдэлийн сан)	5,556,459.95	1.9%	5,681,634.03	2.1%	125,174.08	2.3%
Авлага	9,786,291.97	3.4%	19,287,202.70	7.2%	9,500,910.73	97.1%
Байгууллага, хүмүүсээс авах авлага	970,876.91	0.3%	10,465,611.57	3.9%	9,494,734.65	978.0%
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	8,815,415.06	3.0%	8,821,591.14	3.3%	6,176.08	0.1%
Бусад эргэлтийн хөрөнгө	1,040,305.03	0.4%	1,306,373.51	0.5%	266,068.49	25.6%
Өмчлөх бусад хөрөнгө /цэвр/	687,771.30	0.2%	812,346.65	0.3%	124,575.35	18.1%
Өмчлөх бусад хөрөнгө	694,985.76	0.2%	850,659.97	0.3%	155,674.21	22.4%
(Өмчлөх бусад хөрөнгийн хасагдуулга)	7,214.46	0.0%	38,313.32	0.0%	31,098.86	431.1%
Эргэлтийн бус хөрөнгө	11,421,591.99	3.9%	4,138,316.19	1.6%	-7,283,275.80	-63.8%
Үндсэн хөрөнгө /цэвр/	3,988,909.39	1.4%	3,951,750.67	1.5%	-37,158.72	-0.9%
Үндсэн хөрөнгө	5,897,232.39	2.0%	6,156,415.80	2.3%	259,183.41	4.4%
(Хуримтлагдсан элэгдэл)	1,908,323.00	0.7%	2,204,665.13	0.8%	296,342.13	15.5%
Биет бус хөрөнгө	7,417,196.47	2.6%	171,545.52	0.1%	-7,245,650.95	-97.7%
Биет бус хөрөнгө	7,520,960.49	2.6%	315,828.11	0.1%	-7,205,132.38	-95.8%
(Биет бус хөрөнгийн элэгдэл)	103,764.02	0.0%	144,282.59	0.1%	40,518.58	39.0%
Хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө	15,486.13	0.0%	15,020.00	0.0%	-466.13152	-3.0%
Хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө	15,486.13	0.0%	15,020.00	0.0%	-466.13152	-3.0%
Хөрөнгийн дүн	289,371,682.20	100.0%	266,660,249.42	100.0%	-22,711,432.78	-7.8%

Зураг 5: Хөрөнгийн зарим үзүүлэлтээс /мянган төгрөгөөр/




2022 оны 3 дугаар улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 266,660,249.42 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.8 хувь буюу 22,711,432.78 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт хөрөнгийн 98.4 хувийг эргэлтийн хөрөнгө, 1.6 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байгаа бол мөнгөн хөрөнгө нийт хөрөнгийн 11.4 хувийг, цэвр зээл 78.9 хувийг тус тус эзэлж байна.

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 3.9 хувь буюу 8,021,087.73 мянган төгрөгөөр өсөж 216,086,474.94 мянган

төгрөгт хүрсэн бөгөөд 5,681,634.03 мянган төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 210,404,840.91 мянган төгрөгийн цэвр зээлийн үлдэгдэлтэй байна. Харин хугацаа хэтэрсэн зээл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.9 хувь буюу 327,261.75 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгийн өөрчлөлтийг сүүлийн 5 жилээр харьцуулахад 2018-2021 онуудад тусгай зөвшөөрөлтэй ХЗХ-дын тоо буурсан ч хөрөнгийн хэмжээ тасралтгүй өссөн үзүүлэлттэй байна.

График 7: ХЗХ-дын тоо болон нийт хөрөнгийн өөрчлөлт /тэрбум төгрөгөөр/



3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар

ХЗХ-дыг хөрөнгийн хэмжээгээр нь ангилахад 10 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 4 ХЗХ-ны нийт хөрөнгө 155,563,374.42 мянган төгрөг нь зах зээлийн нийт хөрөнгийн 58.3 хувийг, гишүүдийн тоо 21,430 байгаа нь нийт гишүүдийн 29.4 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 10: ХЗХ-дын хөрөнгийн төвлөрөл, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Нийт хөрөнгө		Гишүүд	
			Дүн	Хувь	Тоо	Хувь
1	10,000,000.0-аас дээш	4	155,563,374.42	58.3%	21,430	29.4%
2	1,000,000.0 -10,000,000.0	26	77,060,131.28	28.9%	23,762	32.7%
3	500,000.0-1,000,000.0	19	13,216,782.47	5.0%	7,644	10.5%
4	100,000.0-500,000.0	76	16,416,057.93	6.2%	13,968	19.2%
5	50,000.0-100,000.0	48	3,572,338.24	1.3%	4,244	5.8%
6	10,000.0-50,000.0	24	802,122.72	0.3%	1,577	2.2%
7	10,000.0 хүртэл	5	29,442.35	0.01%	145	0.2%
Нийт дүн		202	266,660,249.42	100.0%	72,770	100.0%

10 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 4 ХЗХ

ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгийн 58.3%

Нийт гишүүдийн 29.4%

3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар

Тайлант улиралд зах зээл дэх нийт зээлийн үлдэгдэл 216,086,474.94 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 81.0 хувь, цэвэр зээлийн үлдэгдэл 210,404,840.91 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 78.9 хувийг тус тус эзэлж байна.

Зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 2.4 хувь байна.

1 тэрбум төгрөгөөс дээш зээлийн үлдэгдэлтэй 22 ХЗХ-ны зээлийн дүн зах зээлийн нийт зээлийн 84.1 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 11: ХЗХ-дын зээлийн хэмжээ, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Зээлийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Зээлийн дүн	Эзлэх хувь
1	1,000,000.0 дээш	22	181,727,547.99	84.1%
2	500,000.0-1,000,000.0	21	15,290,094.21	7.1%
3	100,000.0-500,000.0	67	14,559,618.37	6.7%
4	50,000.0-100,000.0	46	3,266,666.85	1.5%
5	10,000.0-50,000.0	38	1,218,725.86	0.6%
6	10,000.0 хүртэл	5	23,821.67	0.0%
7	Зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй	3	-	-
Нийт дүн		202	216,086,474.94	100.0%

3.4 Зээлийн чанарын талаар

Хүснэгт 12: Зээлийн ангиллын мэдээлэл /мянган төгрөгөөр/

Зээлийн ангиллын мэдээлэл	Зээлдэгчийн мэдээлэл		Зээлийн үлдэгдэл	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Нийт	38,212	100.0%	216,086,474.94	100.0%
Хэвийн	31,235	81.7%	203,009,266.12	93.9%
Хугацаа хэтэрсэн	5,481	14.3%	5,228,926.46	2.4%
Чанаргүй	1,496	3.9%	7,848,282.36	3.6%
<i>Хэвийн бус</i>	546	36.5%	2,630,755.96	33.5%
<i>Эргэлзээтэй</i>	392	26.2%	1,121,975.30	14.3%
<i>Муу</i>	558	37.3%	4,095,551.10	52.2%


2022 оны 3 дугаар улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн хэмжээнд нийт зээлийн үлдэгдлийн 93.9 хувь буюу 203,009,266.12 мянган төгрөгийг хэвийн зээл, 2.4 хувь буюу 5,228,926.46 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, 3.6 хувь буюу 7,848,282.36 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж

байна. Тайлант хугацаанд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 13,077,208.82 мянган төгрөгийн үлдэгдэлд 43.4 хувь буюу 5,681,634.03 мянган төгрөгийн зээлийн эрсдэлийн санг байгуулсан байна.

Зээлдэгчдийн мэдээллийг зээлийн чанараар ангилахад нийт зээлдэгчийн 81.7 хувийг хэвийн, 14.3 хувийг хугацаа хэтэрсэн, 3.9 хувийг чанаргүй зээл эзэлж байна. Чанаргүй зээлийн үлдэгдэлтэй

1,496 зээлдэгчийн 7,848,282.36 мянган төгрөгийн үлдэгдлийн 33.5 хувийг хэвийн бус, 14.3 хувийг эргэлзээтэй, 52.2 хувийг муу зээлийн үлдэгдэлтэй зээлдэгчид тус тус эзэлж байна.

График 8: Зээлийн чанар



Тайлант улиралд нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хувь хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.5 пунктээр өсөж 93.9 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн хувь хэмжээ 0.3 пунктээр буурч 2.4 хувь, чанаргүй зээлийн хувь хэмжээ 0.2 пунктээр буурч 3.6 хувьд хүрсэн байна.


Хүснэгт 13: Зээлийн ангиллын мэдээлэл хот, орон нутгаар /мянган төгрөгөөр/

Зээлийн ангиллын мэдээлэл	Улаанбаатар хот			Орон нутаг		
	Дүн	Хувь	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Хувь	Нийт дүнд эзлэх хувь
Нийт	167,904,442.86	100.0%	77.7%	48,182,032.09	100.0%	22.3%
Хэвийн	157,394,707.17	93.7%	77.5%	45,614,558.95	94.7%	22.5%
Хугацаа хэтэрсэн	3,843,967.82	2.3%	73.5%	1,384,958.64	2.9%	26.5%
Чанаргүй	6,665,767.86	4.0%	84.9%	1,182,514.49	2.5%	15.1%
Хэвийн бус	2,113,151.23	31.7%	80.3%	517,604.73	43.8%	19.7%
Эргэлзээтэй	832,509.42	12.5%	74.2%	289,465.88	24.5%	25.8%
Муу	3,720,107.21	55.8%	90.8%	375,443.89	31.7%	9.2%

Зээлийн ангиллын мэдээллийг хот, орон нутгаар ангилан харвал ХЗХ-ны зах зээлийн нийт зээлийн 77.7 хувь буюу 167,904,442.86 мянган төгрөгийг Улаанбаатар хотын ХЗХ-д, 22.3 хувь буюу 48,182,032.09 мянган төгрөгийг орон нутгийн ХЗХ-дын зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Улаанбаатар хотын ХЗХ-дын зээлийн үлдэгдлийн 93.7 хувь буюу 157,394,707.17 мянган төгрөгийг хэвийн, 2.3 хувь буюу 3,843,967.82 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн, 4.0 хувь буюу 6,665,767.86 мянган төгрөгийн чанаргүй

зээлийн үлдэгдэл эзэлж байна. Чанаргүй зээлийн үлдэгдлийн 55.8 хувь буюу 3,720,107.21 мянган төгрөгийг муу зээлийн үлдэгдэл бүрдүүлж байгаа бөгөөд зах зээлийн нийт муу зээлийн 90.8 хувийг эзэлж байна. Орон нутгийн ХЗХ-дын зээлийн үлдэгдлийн 94.7 хувь буюу 45,614,558.95 мянган төгрөгийг хэвийн, 2.9 хувь буюу 1,384,958.64 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн, 2.5 хувь буюу 1,182,514.49 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

График 9: Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/



Хүснэгт 14: Зээлийн бүтээгдэхүүнээр /мянган төгрөгөөр/

№	ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ	Зээлийн эхний үлдэгдэл /дүн/	Тайлант хугацаанд олгосон зээл	Тайлант хугацаанд эргэн төлөгдсөн зээл	Зээлийн эцсийн үлдэгдэл	Зээлийн үлдэгдлийн нийт зээлд эзлэх хувь
1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	7,011,488.42	11,233,445.40	9,129,678.38	9,115,255.44	4.2%
2	Уул уурхай, олборлолт	2,127,565.19	1,725,498.12	1,538,297.55	2,314,765.76	1.1%
3	Боловсруулах үйлдвэрлэл	1,606,230.25	1,785,975.21	1,519,261.42	1,872,944.04	0.9%
4	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	685,809.65	871,427.56	927,758.86	629,478.35	0.3%
5	Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	112,319.14	214,047.45	265,142.05	61,224.54	0.0%
6	Барилга	6,987,374.26	7,908,076.09	6,526,102.90	8,369,347.44	3.9%
7	Бөөний болон жижиглэн худалдаа	14,447,117.32	22,415,579.16	20,359,915.70	16,502,780.77	7.6%
8	Машин мотоциклийн засвар үйлчилгээ	3,015,805.78	3,397,210.12	2,454,909.95	3,958,105.95	1.8%
